



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/70

Сүхбаатар сум

Ой, хээрийн түймрээс урьдчилан
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3. "м", "н", 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.6, 17.2.7, 17.2.14, 17.2.16, 17.2.18, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.6, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 37 дугаар зүйлийн 37.1, 40 дүгээр зүйлийн 40.1, Засгийн газрын "Шинэ Коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2020 оны 30 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай" А/76 дугаар тушаал, Улсын Онцгой комиссын 2021 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий цаг хугацаа буюу 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд ойд мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглах, ойд аялал зугаалгаар явах, ан хийх, бугын эвэр түүх болон бусад үйл ажиллагаа явуулахыг аймгийн хэмжээнд түр зогсоосугай.

2. Түймэр гарах эрсдэлтэй үе эхэлж байгаатай холбогдуулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, малчин айл өрх, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, бусад байгууллагуудтай хамтран морьт эргүүл, харуул томилон гэрээ байгуулан ажиллахыг сумдын Засаг дарга, сумын болон сум дундын Ойн ангийн дарга нарт тус тус даалгасугай.

3. Сум орон нутгийн хэмжээнд "Ковид-19" халдварт цар тахал халдварт өвчнөөс хүн ам, түймэр унтраах 1, 2 дугаар бүлгийн бүрэлдэхүүнийг урьдчилан сэргийлэх, хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор эрүүл мэндийн салбар болон төрийн бусад байгууллагын албан хаагчдад нэн хэрэгцээтэй эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөц бүрдүүлэн гал түймэр унтраах бүлгийн гишүүд, орон нутгийн иргэдээс тандалт асуумж, судалгаа авч түймэр унтраах ажиллагаанд дайчлахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Ойн санг гэрээгээр эзэмшигч, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудын ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх ажлын хүрээнд хийгдэж буй ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, явц, үр дүнгийн талаар аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /З.Түвшинтөгс/, Мэргэжлийн хяналтын газрын дарга / Д.Баттүвшин/ нарт тус тус үүрэг болгосугай.

5. Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүн, машин техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, түймрийн мэдээллийг шуурхай солилцох, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж аймгийн Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт дээрх хугацаанд байнгын жижүүрийг тодорхой удирдамжтай ажиллуулахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа /Г.Галбадрах/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /З.Түвшинтөгс/ нарт тус тус даалгасугай.

6. Ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд шалтгаан нөхцөлийг хуулийн хугацаанд шалган тогтоож, эзэн холбогдогчдод хариуцлага тооцож, авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлж байхыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Баттүвшин/ нарт тус тус үүрэг болгосугай.

7. Хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэр, хил дамнан ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд түймрийн тархалтыг таслан зогсоох зорилгоор хоёр улсын томилгоот албан хаагчдыг хялбаршуулсан журмаар хил нэвтрүүлэх ажлыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж ажиллахыг Хилийн 0243 дугаар ангийн захирагч /хурандаа Б.Гантөмөр/-д даалгасугай.

8. Түймрийн аюултай үе буюу хаврын улиралд хуурайшилтын зэргийг сум бүрээр тогтоож, хуурайшилтын зэрэг "аюултай", "нэн аюултай" түвшинд хүрсэн үед сум орон нутаг, иргэдэд түймрээс урьдчилан сэргийлэх хамгаалах талаар сэрэмжлүүлэг, мэдээ мэдээлэл явуулах, агаарын хэт халалт үргэлжлэх үед үүлэнд зориудаар нөлөөлөх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Энхсэлэнгэ /-д даалгасугай.

9. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хилийн цэргийн 0243 дугаар анги, Цагдаагийн газар, Ус цаг уур орчны шинжилгээний төв, сумын болон сум дундын Ойн ангиудын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

10. Түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, унтраасан тухай ажлын тайланг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Ой, хээрийн түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дарга /Ж.Сайнцог/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Ж.САЙНЦОГ